

### Үйл ажиллагааны зарчим:

Баянбөмбөгөр ТББ нь гаргаж буй бодлого, шийдвэр, явуулж буй үйл ажиллагаандаа гишүүдээ идэвхтэй оролцуулан, шийдвэр гаргах бүхий л үйл явцыг нээлттэй, ардчилсан зарчмаар явуулахыг эрхэмлэдэг бөгөөд үүний хамгийн тод илэрхийлэл нь Бүх гишүүдийн хурал юм. ТББ-ын гишүүнээр элссэн хэн боловч Бүх гишүүдийн хурлаар дамжуулан өөрийн үзэл бодол, дуу хоолойгоо шийдвэр гаргах түвшинд илэрхийлэх боломжтой.



### Та Баянбөмбөгөр ТББ-ын гишүүнээр элсэхийг хүсвэл:

1. Тус ТББ-ын гишүүн нь 18 нас хүрсэн Бөмбөгөр сумын байнгын оршин суугч байх бөгөөд Хувиараа ашигт малтмал олборлогч иргэн байх шаардлагатай.
2. Баянбөмбөгөр ТББ-ын зорилгыг дэмжиж, дүрмийг хүлээн зөвшөөрсөн байна.



### Баянбөмбөгөр ТББ-тай хамтран ажилладаг байгууллагууд:

- Тогтвортой Бичил Уурхай Төсөл
- Бөмбөгөр сумын Засаг даргын тамгын газар,
- Иргэдийн Төлөөлөгчдын Хурал
- Сумын Хүний их эмчийн салбар
- Сумын Байгаль орчны хэсэг

### Манай хаяг:

Баянхонгор аймаг, Бөмбөгөр сум  
Харилцах утас: 98308076, 98309286

Баянхонгор аймаг, Бөмбөгөр сум

## "Баянбөмбөгөр" Төрийн Бус Байгууллага



ТАНИЛЦУУЛГА



Тогтвортой  
бичил уурхай  
төсөл

# “БАЯНБӨМБӨГӨР” Төрийн бус байгууллага

## Эрхэм зорилго:

Бөмбөгөр суманд хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн эрх ашгийг хамгаалан, тэдний ажиллах нөхцөлийг хангах, бизнесийг нь дэмжих үйл ажиллагааг явуулж, орон нутгийнхаа хөгжилд хувь нэмрээ оруулах

## Бидний түүх:

1999-2002 оныг дамнан бий болсон ган зудын улмаас малгүй болсон иргэд амьдрахын эрхэнд хувиараа ашигт малтмал олборлож эхэлсэнээс хойш өдгөө 10 шахам жил өнгөрчээ. Анх ямар нэгэн эмх, цэгц, зохион байгуулалтгүйгээр гар аргаар алт олборлож байсан хувиараа ашигт малтмал олборлогч иргэд бид нийгмийн хариуцлагатай гишүүн болж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага бусад салбарын хамт олонтой хамтран ажиллаж сүм орон, нутгийнхаа хөгжилд хувь нэмрээ оруулан, хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах зорилгоор 2008 оны 10 сард Баянбөмбөгөр ТББ-ыг байгуулсан юм. Өнөөдрийн байдлаар манай ТББ нь Монгол Улсын Засгийн газрын 72-р тогтоолоор батлагдсан “Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах” Түр журмын хүрээнд нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон 170 –н гишүүд, дэмжигчтэй болоод байгаа бөгөөд Тэргүүнээр Л.Дамба, олон нийттэй харилцах ажилтнаар Ж.Саруул нар ажиллаж байна.

## Бүтэц зохион байгуулалт:

Манай ТББ-ын эрх барих дээд байгууллага нь Бүх гишүүдийн Хурал бөгөөд тухайн хурлаас томилогдсон Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Техникийн дэд зөвлөл, Нийгмийн дэд зөвлөлийн үйл ажиллагаагаар дамжуулан гишүүддээ хүрч ажилладаг.

## Удирдах зөвлөл:

ТББ-ын дүрэмд зааснаар Удирдах зөвлөл нь Бүх Гишүүдийн Хурлаас баталсан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, гишүүддээ сурталчилан таниулах, Бүх гишүүдийн хурлаас баталсан ТББ-ын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг бусад дэд зөвлөлүүдийн хамтаар хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй. Баянбөмбөгөр ТББ нь Удирдах зөвлөлийн 13 гишүүнтэй ажиллаж байна.

## Хяналтын зөвлөл:

Хяналтын зөвлөл нь Бүх Гишүүдийн Хурлаас баталсан бодлого, шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, санхүүгийн зарцуулалтын үйл ажиллагаанд сар бүр хяналт тавих үндсэн үүрэгтэй бөгөөд тус ТББ-ын хөрөнгө, санхүүгийн байдалд шалгалт хийж дүгнэлт гарган жил бүрийн эцэст бүх гишүүдийн хуралд тайлагнах үүрэгтэй.

Баянбөмбөгөр ТББ-ын Хяналтын зөвлөл нь 3 хүний бүрэлдхүүнтэй ажилладаг.



## Техникийн дэд зөвлөл:

Хувиараа ашигт малтмал олборлогч гишүүдийнхээ олборлолт болон ашиглалтын техник, технологийг сайжруулахад холбогдох талуудтай хамтран ажиллаж, дундын эзэмшлийн трактор аишглалтын төлөвлөгөөг боловсруулж, нөхөрлөлүүдийн газар ашиглах, нөхөн сэргээлт хийх хуваарийг улирлаар нь гарган Удирдах зөвлөлөөр батлуулан, бүх гишүүдэд мөрдүүлж ажиллах үндсэн үүрэгтэй.

Техникийн дэд зөвлөл нь 6 хүний бүрэлдхүүнтэй бөгөөд ахлагч нь Б.Нарангэрэл

## Нийгмийн дэд зөвлөл:

Баянбөмбөгөр ТББ-ын гишүүн бөгөөд амьжиргааны түвшин доогуур, өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах, тэдний дүү хоолойг ТББ-ын шийдвэр гаргах түвшинд хүргэх, бизнес санаачлагыг нь дэмжин, ажил хэрэг болгоход үйл ажиллагааных нь гол чиглэл оршдог. Нийгмийн дэд зөвлөл нь 6 хүний бүрэлдхүүнтэй бөгөөд ахлагчаар нь ТББ-ын идэвхжүүлэгч Ж. Саруул сонгогдон ажиллаж байна.

